

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 09-р сарын 17-ны өдөр

Дугаар 15


Улаанбаатар хот

Дотоод хяналтын хөтөлбөр батлах тухай

Мөнгө Угаах Болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Тухай хуулийн 14.1 заалтыг үндэслэн тус тус **ТОГТООХ НЬ:**

1. 2019 оны 03 сарын 15-ны өдөр батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр” болгон шинэчлэн боловсруулж, хавсралтаар баталсугай.
2. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын ажилтан Н.Батгэрэл-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн /цаашид компани гэх/ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд чиглэнэ.
- 1.2 Энэхүү хөтөлбөр нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /МУТС-тэй тэмцэх хууль/, Санхүүгийн зохицуулах хорооны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” зэрэг холбогдох хууль, журмуудыг мөрдлөг болгоно.

Хоёр. Хөтөлбөрийн чиг үүрэг

- 2.1 Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 2.2 Сэжигтэй болон мөнгөн гүйлгээний тайлан мэдээллийг хууль, журамд заасны дагуу холбогдох байгууллагад мэдээлэх;
- 2.3 Холбогдох хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, эрсдлийн үнэлгээг улирал бүр хийж удирдлагад тайлагнах;
- 2.4 Компанийн ажилтнуудад харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тэмцэх чиглэлээрх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх.

Гурав. Харилцагчийг таньж мэдэх

- 3.1 Компани нь харилцагчийн үнэт цаасны дансыг нээхийн өмнө Санхүүгийн зохицуулах хорооны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” –ын 5 дугаар зүйлийн дагуу харилцагчаас холбогдох мэдээллийг авч таньж мэднэ. Үүнд:
 - 3.1.1 Харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, эрхэлж буй ажил, бизнес иргэний үнэмлэх, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 3.1.2 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчид, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээдийн бүтэц, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн хуулийн этгээдийн мэдээлэл;
 - 3.1.3 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон

- харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;
- 3.1.4 Харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;
- 3.1.5 Харилцагч нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эсхүл хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгчийг ил тод мэдээлэх үүрэгтэй бол харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагааг хийж болно.
- 3.2 Эрсдэлтэй харилцагч, түүнийг таньж мэдэх;
- 3.2.1 Эрсдэлтэй харилцагч гэж:
- 3.2.1.1 Улс төрд нөлөө бүхий этгээд түүнтэй адилтгаж болох эрх бүхий этгээдүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд;
- 3.2.1.2 МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий ОУ-н байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;
- 3.2.1.3 МУТС-тэй тэмцэх үндэсний эрсдлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд;
- 3.2.2 Эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх:
- 3.2.2.1 Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн, харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авсан мэдээллийг эргэж хянах;
- 3.2.2.2 Харилцагчийг үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээлэл, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг шинэчлэн авах;
- 3.2.2.3 Энэхүү хөтөлбөрийн Хавсралт-1 эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.3 Компани нь харилцагчтай нэмэлт нөхцөлтэй гэрээ байгуулсан тохиолдолд харилцагчтай компани гэрээ байгуулж хавсралтад заасан “Харилцагчаа таних” маягыг бөглүүлнэ.
- 3.4 Бизнесийн харилцаа эхлүүлэхээс өмнө тухайн харилцагч нь Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээд мөн эсэхийг <http://amlcft.mn/> холбоосыг ашиглан заавал шалгана. /Баталгаажуулах зорилгоор <https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list> холбоосоор хандан НҮБ-н албан ёсны веб хуудсанд байршуулсан жагсаалтаас тулган шалгаж болно.
- 3.5 Компани нь шаардлагатай тохиолдолд харилцагчаас мэдээллийг шинэчлэн авна.

Дөрөв.Сэжигтэй болон Мөнгөн гүйлгээний мэдээллийг мэдээлэх

- 4.1 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.

- 4.2 Компани нь Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 4.3 Харилцагч нь компанид худал эсхүл хуурамч бичиг баримт, мэдээлэл өгсөн бол СМА-нд сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлнэ.
- 4.4 Компани нь мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээллийн албанд түүний баталсан маягт, журмын дагуу хүргүүлнэ.
- 4.5 Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:
 - 4.5.1 Компанийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 4.5.2 Харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;
 - 4.5.3 Тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;
 - 4.5.4 Тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;
- 4.6 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь тодорхой нэг гүйлгээ, харилцагчийн талаар Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэл өгснийг байгууллагын болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.
- 4.7 Компанийн удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчдад ямар нэг байдлаар мэдэгдэхийг хориглоно.

Тав. Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан

- 5.1 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг компанийн “Back Office” алба хариуцах ба тухайлсан мэргэжилтэнг албаны менежер хариуцан томилно.
- 5.2 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь холбогдох хууль, журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 5.3 Мэдээлэх үүрэгтэй ажилтны ажлын гүйцэтгэлд албаны менежер хяналт тавьж ажиллана.
- 5.4 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно:
 - 5.4.1 Хууль тогтоомжийн дагуу мэдээлэхээс зөвшөөрснөөс бусад хувь хүн, хуулийн этгээдэд харилцагчийн гүйлгээний талаар мэдээлэх;
 - 5.4.2 Мэдээлэх үүрэгтэй ажилтан болон бусад бүх ажилчид нь албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.
- 5.5 Мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтан нь мэдээлэх үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн тайланг энэхүү хөтөлбөрийн хавсралт маягтын дагуу компанийн ТУЗ-д улирал тутам танилцуулна.
- 5.6 Компани нь сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх үүрэгтэй ажилтны аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хамгаалах нөхцөлийг хангаж ажиллана.
- 5.7 Мэдээлэх үүрэгтэй этгээдийг хариуцлагаас чөлөөлөх
 - 5.7.1 Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны,

- мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй
- 5.7.2 Мэдээлэх үүрэгтэй этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- 5.7.3 Тодорхой гүйлгээг МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

Зургаа. Санхүүгийн хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх

- 6.1 Компани Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад нийцүүлэн МУТС тэмцэх тухай хуулийн 6.1.-т заасны дагуу баталсан хориг арга хэмжээний жагсаалт орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 6.2 Компани нь харилцагчтай бизнесийн харилцаа эхлүүлэхээс өмнө тус хөтөлбөрийн 3.4-т заасны дагуу тухайн харилцагчийн мэдээллийг дурдсан эх сурвалжаас шалгаж, баталгаажуулна.
- 6.3 Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, холбоо, бүлэглэл, байгууллага болон тэдгээрийн нэрийн өмнөөс шууд болон шууд бусаар эсхүл тэдгээрийн зааврын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн хөрөнгө, мөнгө байгаа гэж үзвэл дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.3.1 Хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр данс, хөрөнгийн хөдөлгөөнийг нэн даруй зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх, захиран зарцуулах боломжгүй болгох;
- 6.3.2 Хөдөлгөөнгүй болгосон хөрөнгө, мөнгө, түүний өмчлөгч болон захиран зарцуулагчтай холбоотой мэдээлэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Санхүү мэдээллийн алба болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргүүлэх;
- 6.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу данс, гүйлгээг царцаах, сэжиглэхтэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагын ажилтнаас бусад хувь хүн, хуулийн этгээдэд задруулахыг хориглоно.

Долоо. Дотоод хяналт

- 7.1 Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих Дотоод хяналтын ажилтныг компанийн ТУЗ эсвэл Гүйцэтгэх удирдлагаас томилох ба уг ажилтан нь удирдах түвшний албан тушаалтан байна.
- 7.2 Компанийн албадын мэргэжилтнүүд нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ба өдөр тутмын хяналтыг албаны менежер хийж гүйцэтгэнэ.
- 7.3 Дотоод хяналтын ажилтан нь ээлжит болон ээлжит бус шалгалт хийх замаар энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.

- 7.4 Дотоод хяналтын ажилтан нь компанийн салбар нэгж албадуудаас шаардлагатай бүх баримт бичиг, харилцагчийн болон гүйлгээний талаарх баримт мэдээлэлтэй танилцах, шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнаас гаргуулан авах эрхтэй.
- 7.5 Хариуцлагыг “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Дотоод үйл ажиллагааны журмын дагуу шийдвэрлэнэ.

Найм. Дотоод сургалт

- 8.1 Компани нь МУТС-тэй тэмцэх тухай хууль, холбогдох журам түүний өөрчлөлт, эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалт семинарт холбогдох мэргэжилтнийг хамруулж, уг мэргэжилтнээр дамжуулан дотооддоо сургалт мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж ажиллана.
- 8.2 МУТС-тэй тэмцэх тухай хууль эрх зүйн орчин, холбогдох дүрэм, журмууд, хууль эрх зүйн актад өөрчлөлт орсон тохиолдолд түүний тухай мэдээллийг тухай бүр ажилчдад хүргэх;
- 8.3 Шинээр ажилд орж байгаа ажилчдад МУТС-тэй тэмцэх тухай хууль эрх зүйн орчин, харилцагчийг таних талаар мэдлэг олгох;

Ес.Эрсдэлийг үнэлэх, хянах

- 9.1 Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн хүчин зүйлсийг дараах 3 ангиллаар үнэлнэ.
 - 9.2.1 Харилцагчаас хамаарах эрсдэлийн хүчин зүйл
 - 9.2.2 Газарзүйн эрсдэлийн хүчин зүйл
 - 9.2.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйл
- 9.2 Эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хавсралт 1 заасан аргачлалаар үнэлж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Арав. Баримт, материалын бүртгэл, хадгалалт

- 10.1 Компани нь харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 10.2 Баримт материалыг нотлох баримтын түвшинд ашиглах боломжийг ханган архивлаж, хадгална.
- 10.3 Мэдээлэх үүрэгтэй ажилтан нь мөнгөн гүйлгээний тайлан болон сэжигтэй гүйлгээний тайлан мэдээг нэгтгэж бүртгэнэ.
- 10.4 Тайлан мэдээ болон холбоотой баримт бичгийг цаасан болон файл хэлбэрээр хадгална.

*“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод
хяналтын хөтөлбөр”-ийн хавсралт Маягт-1*

Тайлангийн маягт

Хамрах огноо:

№	Утга	Гүйлгээний тоо	Гүйлгээний дүн
1	20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайлан		
1.1	Гадаад ААН		
1.2	Дотоод ААН		
1.3	Гадаад иргэн		
1.4	Дотоод иргэн		
	Нийт		
2	Сэжигтэй гүйлгээний тайлан		
2.1	Гадаад ААН		
2.2	Дотоод ААН		
2.3	Гадаад иргэн		
2.4	Дотоод иргэн		
	Нийт		
3	Бусад:		

Тайлан бэлтгэсэн:

Тайлан хянасан:

Эрсдэлийн удирдлагын хөтөлбөр

Эрсдэлтэй харилцагч, эрсдэлтэй үйл ажиллагааг тодорхойлох үйл ажиллагааг доорх эрсдэлийн матрицад тулгуурлан хийнэ. Матрицын үнэлгээг 1-10 оноогоор үнэлэх ба үнэлгээнээс хамааран нарийвчилсан хяналтыг хийж гүйцэтгэнэ.

Эрсдэлийн үнэлгээний матриц		Эрсдэлтэй үйл ажиллагаа		
		Сүүлийн 6 сарын хугацаанд үнэт цаас худалдан авах зорилгоор 10 сая төгрөг болон түүнээс дээш дүнтэй 2 ба түүнээс дээш давтамжтай гүйлгээ	20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ	Өмнөх жилийн ХЗЗ-н арилжааны нийт үнийн дүнгийн 30%-иас дээш дүнтэй гүйлгээ
Харилцагчийн эрсдэлийн хүчин зүйлс	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулсан	1	2	5
	Хөрөнгө, орлогын эх үүсвэр тодорхойгүй	1	3	5
	Насанд хүрээгүй этгээд	1	3	5
	Оршин суугаа/байгаа газар тодорхойгүй	2	4	7
	Баримт бичгийн зөрчилтэй	3	6	8
	Улс төрд нөлөө бүхий этгээд	5	7	10
	Харилцагч нь ойлгоход төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд	1	3	5
	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл тодорхойгүй	1	3	5

	МУТС-тэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд	6	7	10
Газар зүйн байршил, бүс нутгийн эрсдэлийн хүчин зүйлс	ОУ-ын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын иргэн, хуулийн этгээд	6	7	10
	Санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалат болон ижил төстэй арга хэмжээнд орсон улсын иргэн, хуулийн этгээд	6	7	10
	Найдвартай эх сурвалжаас авлига хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон улсын иргэн, хуулийн этгээд	2	4	7
Бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчид хүргэх хэлбэрээс хамаарах хүчин зүйлс	Өөрийн биеэр ирэлгүй хийсэн гүйлгээ, арилжаа /Онлайн брокер үйлчилгээ/	1	3	5
	Номинал дансаар дамжуулан төлбөр тооцоо гүйцэтгэх	1	3	5

Дээрх эрсдэлийн үнэлгээний матрицын дагуу үнэлэгдсэн онооноос хамааран дараах нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1-5 оноо:

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой шаардлагатай мэдээллийг шинэчлэх, нэмэлтээр гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх

6-15 оноо:

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой шаардлагатай мэдээллийг шинэчлэх, нэмэлтээр гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх
4. Харилцагчийг нарийвчлан мэдэх үйл ажиллагааны хүрээнд дэлгэрэнгүй “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн төлөөлөгч болон итгэмжлэгчээр нарийвчилсан “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
6. Харилцагчийн дансанд хийгдэж байгаа гүйлгээг сэжигтэй гэж үзэх үндэслэлтэй бол мээдэлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд мэдэгдэж, батлагдсан маягтын дагуу Монгол Банкны СМА-нд мэдээлнэ.

16 болон түүнээс дээш оноо:

1. Компани нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг боломжийн хүрээнд шалгаж, хянах
2. Тухайн харилцагчаас эрхэлж буй ажил, бизнесийн болон хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах
3. Харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавих давтамжийг нэмэгдүүлэх
4. Харилцагчийг нарийвчлан мэдэх үйл ажиллагааны хүрээнд дэлгэрэнгүй “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гүйлгээ хийсэн бол итгэмжлэгдсэн төлөөлөгч болон итгэмжлэгчээр нарийвчилсан “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
6. Харилцагчийн дансанд хийгдэж байгаа гүйлгээг сэжигтэй гэж үзэх үндэслэлтэй бол мээдэлэх үүргийг хэрэгжүүлэх ажилтанд мэдэгдэж, батлагдсан маягтын дагуу Монгол Банкны СМА-нд мэдээлнэ.

7. Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна. Энэ зөвшөөрөл нь энэхүү хөтөлбөрийн хүрээнд явагдах бөгөөд компанийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс өндөр МУТС эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах эрхтэй.

Харилцагчийн мэдээллийг нарийвчлан хянах

Харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах үйл ажиллагааг дараах шаардлагын дагуу хийнэ.

1. ХАРИЛЦАГЧ ИРГЭН БОЛ:

1.1 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэх

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Овог нэр, регистр, төрсөн огноо	Иргэний үнэмлэхийн эх хувь эсвэл иргэний үнэмлэхийн лавлагаанд үндэслэн тухайн харилцагч мөн эсэхийг шалгах. /Бичиг баримтын хүчинтэй хугацааг шалгах/
Байнгын оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар, тухайн харилцагчийн нэр дээрх банкны данс	Иргэний үнэмлэх, иргэний үнэмлэхийн лавлагаан дээрх хаягийг бүртгэх. Тухайн хаягаас шилжсэн тохиолдолд шилжин ирсэн хуудсаар мэдээллээр бүртгэх.
Эрхэлж буй ажил, бизнес	Тухайн харилцагчийн эрхэлдэг ажил мэргэжлийг харилцагчаас лавлах
Өөр хэн нэгэн этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийх тохиолдолд	Иргэний хуулийн 64.2 дах заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийн үндэслэн данс нээх, Итгэмжлэлд Үнэт цаасны данс нээлгэх эрхийг олгосон эсэхийг шалгах.

1.2 Номинал данс нээлгэх

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Овог нэр, регистр, төрсөн огноо	Иргэний үнэмлэхийн эсвэл гадаад паспортыг үндэслэн тухайн харилцагч мөн эсэхийг шалгах. /Бичиг баримтын хүчинтэй хугацааг шалгах/
Харилцагчаа таних маягт	Харилцагч компанитай номинал дансны үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний хавсралт болох “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
Өөр хэн нэгэн этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийх тохиолдолд	Иргэний хуулийн 64.2 дах заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийн үндэслэн данс нээх, Итгэмжлэлд номинал данс нээлгэх эрхийг олгосон эсэхийг шалгах. Насанд хүрээгүй этгээдийг төлөөлж байгаа тохиолдолд Төлөөлөх этгээдийн иргэний үнэмлэх, төлөөлөх этгээдийн мэдээллийг бүртгэнэ.

1.3 Данснаас мөнгө гаргах хүсэлтийг хүлээн авах

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Овог нэр, регистр, төрсөн огноо	Иргэний үнэмлэхийн эх хувь эсвэл иргэний үнэмлэхийн лавлагаанд үндэслэн тухайн харилцагч мөн эсэхийг шалгах. /Бичиг баримтын хүчинтэй хугацааг шалгах/
Банк дах дансны мэдээлэл	Тухайн харилцагчийн нэр дээрх банкны данс. /Мөнгө хүсэх өргөдлийн дагуу зөвхөн тухайн харилцагчийн нэр дээрх банкны данс руу гүйлгээ хийгдэнэ/
Өөр хэн нэгэн этгээдийг төлөөлөн гүйлгээ хийх тохиолдолд	Иргэний хуулийн 64.2 дах заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийг үндэслэн данс нээх, Итгэмжлэлд данснаас мөнгө хүсэх өргөдөлд гарын үсэг зурах эрхийг олгосон эсэхийг шалгах. /Зөвхөн данс эзэмшигчийн банкны дансны мэдээллээр гүйлгээ хийгдэнэ/

1.4 “Онлайн брокер” үйлчилгээний гэрээ байгуулах

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Овог нэр, регистр, төрсөн огноо	Иргэний үнэмлэхийн эх хувилбар шаардлагатай бөгөөд тухайн харилцагч мөн эсэх, /Бичиг баримтын хүчинтэй хугацааг шалгах/
Харилцагчаа таних маягт	Харилцагч компанитай онлайн брокер үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний хавсралт болох “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
Өөр хэн нэгэн этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийх тохиолдолд	Иргэний хуулийн 64.2 дах заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийг үндэслэн гэрээ байгуулах, Итгэмжлэлд хувьцаа худалдах, худалдан авах болон бусад эрхийг заасан байх. Насанд хүрээгүй этгээдийг төлөөлж байгаа тохиолдолд Төлөөлөх этгээдийн иргэний үнэмлэх, төлөөлөх этгээдийн мэдээллийг бүртгэнэ.

2. ХАРИЛЦАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:

2.1 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэх

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Компанийн нэр, регистр, үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувийг авах
ТУЗ болон ХНХ-ийн шийдвэр	Хуулийн этгээдийн данс дахь хөрөнгийг захиран зарцуулах гарын үсэг зурах албант тушаалтныг томилсон тухай шийдвэр
Гарын үсгийн баталгааны маягт	Дансыг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн гарын үсгийн баталгааны маягтыг нотариатаар баталгаажуулах /ҮЦТХТ болон АТТ ХХК-ийн баталсан маягт/
Данс нээлгүүлэх хүсэлт	Данс нээлгэх тухай болон мэдээлэл хүргүүлсэн тухай агуулга бүхий албан бичиг
Компанийн дүрэм	Компанийн дүрмийн хуулбарыг авах

2.2 Номинал данс нээлгэх

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Компанийн нэр, регистр, үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувийг авах
ТУЗ болон ХНХ-ийн шийдвэр	Хуулийн этгээдийн данс дахь хөрөнгийг захиран зарцуулах 1, 2-р гарын үсгийг зурах албан тушаалтныг томилсон тухай ТУЗ эсвэл хувьцаа эзэмшигчийн шийдвэр
Харилцагчаа таних маягт	Харилцагч компанитай номинал дансны үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний хавсралт болох “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
Удирдлагын мэдээллийн анкет	Компанийн удирдлагын талаарх мэдээлэл
Компанийн дүрэм	Компанийн дүрмийн хуулбарыг авах

2.3 Данснаас мөнгө гаргах хүсэлтийг хүлээн авах

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Банк дах дансны мэдээлэл	Тухайн хуулийн этгээдийн нэр дээрх банкны данс. Мөнгө гаргах хүсэлтийн дагуу зөвхөн тухайн компанийн нэр дээрх данс руу гүйлгээ хийгдэнэ.
Баталгаат гарын үсэг	Баталгаат гарын үсгийг шалгах
Тамга	Хуулийн этгээдийн тамга дарагдах

2.4 “Онлайн брокер” үйлчилгээний гэрээ байгуулах бол:

Харилцагчийн тухай шаардлагатай мэдээлэл	Мэдээллийг нарийвчлан шалгах
Компанийн нэр, регистр, үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувийг авах
Харилцагчаа таних маягт	Харилцагч компанитай онлайн брокер үйлчилгээний гэрээ байгуулж, гэрээний хавсралт болох “Харилцагчаа таних маягт” бөглүүлэх
ТУЗ болон ХНХ-ийн шийдвэр	Хуулийн этгээдийн данс дахь хөрөнгийг захиран зарцуулах 1, 2-р гарын үсгийг зурах албан тушаалтныг томилсон тухай ТУЗ эсвэл хувьцээ эзэмшигчийн шийдвэр